

ЗАХИАЛАГЧ

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН БАЙГАЛЬ
ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГА

Д.МӨНХЭРДЭН

(Гарын үсэг)

УС А0034 9019197

ГҮЙЦЭТГЭГЧ

“НУТГИЙН БОСГО” ХХК-НЫ
ЗАХИРАЛ

Г.ЦЭЭЭРЭГЗЭН

(Гарын үсэг)

ТТС2886 6 3007349
УЛААНБААТАР ХОТ

**“УСЛАЛТЫН СИСТЕМ ХӨВ ЦӨӨРӨМ БАЙГУУЛАХ АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨВ
БӨЛӨВСРУУЛАХ” ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ**

Дугаар № БОАЖГ/2018/01

Говьсүмбэр аймаг

Нэг талаас: Говьсүмбэр аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас Улаанбаатар хотын “Нутгийн босго” ХХК (цаашид “зөвлөх” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2018 оны 04 сарын 02-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Зөвлөх нь энэхүү гэрээ болон гэрээний салшгүй хэсэг болох Хавсралт №1 -д тодорхойлсон “Ажлын даалгавар болон үйлчилгээний цар хүрээ”-нд заасан зөвлөх үйлчилгээг (цаашид “үйлчилгээ” гэх) үзүүлэх үүрэгтэй.
2. Зөвлөх нь захиалагчаас шаардаж буй мэргэжлийн дадлага туршлага, ажиллах хүчин болон техникийн эх үүсвэртэй бөгөөд гэрээнд заасан нөхцөл, болзлын дагуу үйлчилгээг үзүүлэхийг хүлээн зөвшөөрсөн болно.
3. Захиалагч нь “Услалтын систем, хөв цөөрөм байгуулах ажлын зураг, төсөв боловсруулах” (цаашид “ажил” гэх) 9 700 000 есөн сая долоон зуун мянган төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн Зөвлөхийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
4. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээний ерөнхий нөхцөл;

Гэрээний тусгай нөхцөл;

Хавсралт:

Хавсралт №1 Ажлын даалгавар

Хавсралт №1 Ажиллах хүчний график

Хавсралт №2 Ажлын график


Хавсралт №3 Төсөвт өртөг

Хавсралт №4 Санхүүжилтийн хуваарь

Гэрээ нь энд дурдсан Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно.

5. Захиалагч болон зөвлөх нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

6. Зөвлөх нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
7. Захиалагч нь гэрээний дагуу Зөвлөхийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.



ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Б.Сарантуяа
(Гарын үсэг)

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН БАЙГАЛЬ
ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ТАСРЫН МЭГЭ ЭЖИЛТЭН
Б.САРАНТУЯА

Хаяг: Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум,
3-р баг
Утас:99479679



ЗӨВЛӨХИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Н.Шинэболд
(Гарын үсэг)

“НУТГИЙН БОСГО” ХХК-ИЙН
ЗӨВЛӨХ ИНЖЕНЕР Н.ШИНЭБОЛД
УЛААНБААТ

Хаяг: УБ хот, Баянгол дүүрэг, 17-р хороо
Энэбишийн өргөн чөлөө, 28-1
Харилцах банк: Хаан банк
Данс:5135451738
Утас:91999138

II. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. ЕРӨНХИЙ ЗААЛТ

- 1.2 Гэрээнд хэрэглэгдэх хууль Энэхүү гэрээ, түүний агуулга болон тайлбар, мөн талуудын харилцаа ГТН-д заасан хууль тогтоомжоор зохицуулна.
- 1.3 Гэрээнд ашиглах хэл Энэхүү гэрээ нь ГТН-д заасан Монгол улсын хэл дээр боловсруулагдсан бөгөөд гэрээний агуулга, тайлбартай холбоотой бүх асуудалд уг хэлийг ашиглана. Талууд хоорондын харилцах бичиг баримт нь энэ хэл дээр байна.

2. ГЭРЭЭ ЭХЛЭХ, ДУУСГАВАР БОЛОХ, ТҮҮНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ БОЛОН ЦУЦЛАХ

- 2.1 Гэрээ хүчин төгөлдөр болох Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурсан, эсхүл ГТН-д заасан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Гэрээг хүчин төгөлдөр болох өдрийг гэрээ хүчин төгөлдөр болох огноо гэж хэлнэ.
- 2.2 Үйлчилгээг эхлэх Зөвлөх нь гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш ГТН-д заасан хоногт багтаан үйлчилгээг эхлэх ёстой.
- 2.3 Гэрээний хугацаа дуусгавар болох ГЕН-ийн 2.6-д заасны дагуу цуцлагдаагүй бол гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш ГТН-д заасан хугацааны дараагаар энэхүү гэрээний хугацаа дуусгавар болно.
- 2.4 Гэрээний өөрчлөлт буюу засвар Гагцхүү бичгээр үйлдэн талууд гарын үсэг зурж баталгаажуулсан тохиолдолд гэрээний нөхцөл, болзол болон үйлчилгээний цар хүрээг засварлах, эсхүл өөрчилж болно.
- 2.5 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл
- 2.5.1 Дайн, иргэний бослого, түймэр, үер, халдварт өвчин, газар хөдлөлт, хорио цээр, тээврийн хориг болон бусад гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэнээс захиалагч, эсхүл нийлүүлэгч, эсхүл туслан гүйцэтгэгчийн гэрээний үүргийн гүйцэтгэл хугацаа хоцорсон бол талууд тохиролцон гүйцэтгэх хугацааг сунгана.
- 2.5.2 Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэн тохиолдолд нийлүүлэгч нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ. Захиалагч бичгээр өөрөөр зааварлаагүй бол Зөвлөх гэрээний үүргээ боломжтой хэмжээнд үргэлжлүүлэн гүйцэтгэж, гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлаас үл шалтгаалан гэрээг хэрэгжүүлэх боломжит арга замыг хайна.
- 2.6 Гэрээ цуцлах
- 2.6.1. Захиалагч гэрээг цуцлах Энэхүү зүйлд заасан дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд захиалагч өөрийн санаачлагаар гэрээг цуцлах эрхтэй.
- (а) Зөвлөх гэрээний дагуу хүлээсэн үүргээ зөрчсөн талаарх мэдэгдлийг хүлээн авсны дараагаар 30 хоног, эсхүл захиалагчийн бичгээр зөвшөөрөн сунгасан хугацаанд багтаан мэдэгдэлд дурдсан зөрчлийг арилган үүргийн гүйцэтгэлийг



хангаагүй:

- (б) Зөвлөх (эсхүл түншлэлийн аль нэг гишүүн) төлбөрийн чадваргүй болсон, эсхүл дампуурсан, эсхүл дампуурлаас зайлсхийх зорилгоор зээлдүүлэгчтэй тохиролцсон, эсхүл сайн дураараа буюу албадан журмын дагуу татан буугдаж байгаа;
- (в) Зөвлөх нь тендерт оролцох буюу гэрээг гүйцэтгэх явцдаа авилгал, залилан мэхлэх үйлдэлд холбогдсон байж болох хангалттай үндэслэл захиалагчид байгаа;
- (г) Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл үүссэний улмаас Зөвлөх нь 60-аас дээш хоногийн хугацаанд үйлчилгээний голлох хэсгийг гүйцэтгэх боломжгүй болсон;
- (д) Захиалагч өөрийн санаачлагаар дээр зааснаас бусад үндэслэлээр гэрээг цуцлахаар шийдвэрлэсэн бол;
- (е) Зөвлөх ГЕН-ийн 7 зүйл заасны дагуу арбитрайн ажиллагааны үр дүнд гаргасан эцсийн шийдвэрийг биелүүлээгүй;

2.6.2 Зөвлөхийн санаачлагаар гэрээг цуцлах

Энэхүү зүйлд заасан дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд зөвлөх өөрийн санаачлагаар гэрээг цуцлах эрхтэй


- (а) захиалагч нь ГЕН-ийн 7 дугаар зүйлд заасны дагуу ямар нэгэн маргаан үүсээгүй үед гэрээний дагуу төлбөл зохих аливаа төлбөрийг зөвлөхийн бичгээр гаргасан төлбөрийн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш 45 хоногийн дотор төлөөгүй
- (б) Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл үүссэний улмаас Зөвлөх нь 60-аас дээш хоногийн хугацаанд үйлчилгээний голлох хэсгийг гүйцэтгэх боломжгүй болсон;
- (в) Захиалагч ГЕН-ийн 7 зүйл заасны дагуу арбитрайн ажиллагааны үр дүнд гаргасан эцсийн шийдвэрийг биелүүлээгүй;
- (г) Захиалагч гэрээний дагуу хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн бөгөөд энэхүү зөрчлийн талаарх мэдэгдлийг хүлээн авснаас хойш 45 хоногийн хугацаанд (эсхүл зөвлөхийн бичгээр зөвшөөрөн сунгасан хоногт багтаан) тухайн зөрчлийг арилгаагүй;

2.6.2 Гэрээг цуцласан үед хийх төлбөр

ГЕН-ийн 2.9.1 болон 2.9.2 зүйлд заасны дагуу гэрээг цуцласан үед захиалагч дараах төлбөрийг зөвлөхөд төлөх ёстой:

- (а) Гэрээг цуцлах өдрөөс өмнө зохих ёсоор гүйцэтгэсэн бөгөөд ГЕН-ийн 6 дугаар зүйлд заасны дагуу төлбөл зохих үйлчилгээний хөлс;
- (б) ГЕН-ийн 2.6.1-ийн (а)-гаас (в) хүртлэх, мөн (е) заалтын дагуу гэрээг цуцалснаас бусад тохиолдолд зөвлөхийн ажилтнууд, тэдний хууль ёсны хамтран амьдрагч нарыг буцаах замын зардал зэрэг гэрээг цуцласны улмаас үүсэх аливаа бодит зардлын нөхөн олговор;

3. ЗӨВЛӨХИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ



3.1 Ерөнхий зүйл

3.1.1 Гүйцэтгэлийн чанар

Зөвлөх нь гэрээний дагуу гүйцэтгэвэл зохих үүрэг болон үзүүлэх үйлчилгээг нийтээр хүлээн зөвшөөрөгдөөн мэргэжлийн болон бодит жишигт нийцүүлэн үр ашигтай, хэмнэлтэй байдлаар гүйцэтгэх ёстой бөгөөд тоног төхөөрөмж, машин механизм болон материалын хувьд аюулгүй, үр дүнтэй болон зүй зохист арга зүйг ашиглан үйл ажиллагааны шуурхай удирдлагыг ханган ажиллах ёстой.

Зөвлөх нь гэрээ болон үйлчилгээтэй холбоотой ямарваа нэгэн асуудлаар ямагт захиалагчийн зөвлөхийн хувиар хандан ажиллах бөгөөд туслан гүйцэтгэгч буюу гуравдагч этгээдтэй хийх аливаа харилцаанд захиалагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах ёстой.

3.2 Ашиг сонирхлын зөрчил

Зөвлөх нь ирээдүйд хийх ажилтай холбоотой ямар нэгэн зүйлийг үл харгалзан захиалагчийн ашиг сонирхлыг эн тэргүүнд тавих ёстой бөгөөд өөр төсөл арга хэмжээ буюу өөрийн байгууллагын эрх ашигтай, сонирхолын зөрчилд орохоос зайлсхийх ёстой.

3.3 Нууцлал

Зөвлөх, түүний ажилтнууд нь захиалагчаас урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр гэрээний хэрэгжилтийн явцад олж авсан аливаа нууц мэдээллийг ямар нэгэн хувь хүн, байгууллагад дамжуулах эрхгүй бөгөөд үйлчилгээний үр дүнд боловсруулсан зөвлөмжийг нийтэд нээлттэй болгох эрхгүй.

3.4 Зөвлөхийн хариуцах даатгал

Зөвлөх нь захиалагчийн зөвшөөрсөн нөхцөл, болзолын дагуу болон ГТН-д тусгайлан заасан эрсдэлд хамаарах даатгалыг өөрийн зардлаар хариуцан хийлгэх бөгөөд даатгалын гэрээ, гэрчилгээг захиалагчид ирүүлнэ.

3.5 Захиалагчаас урьдчилан зөвшөөрөл авбал зохих үйл ажиллагаа

Зөвлөх нь дор дурдсан үйл ажиллагааг явуулахаас өмнө захиалагчийн зөвшөөрлийг бичгээр авсан байх ёстой. Үүнд:

- (а) Үйлчилгээний аль нэг хэсгийн гүйцэтгэлийг туслан гүйцэтгэх гэрээгээр хийлгэх,
- (б) Хавсралт №1-т заасан ажилтны жагсаалтанд ямар нэг өөрчлөлт, нэмэлт оруулах.
- (в) ГТН-д тусгайлан заасан бусад үйл ажиллагаа

3.6 Тайлагнах хуваарь

Зөвлөх нь Хавсралт №2 -т заасан тайлан болон баримт бичгийг тухайн хавсралтад заасан маягтын дагуу тогтоосон хугацааны дотор хүргүүлэх ёстой.

3.7 Зөвлөхийн боловсруулсан баримт бичиг захиалагчийн өмч болох нь

Энэхүү гэрээний дагуу захиалагчид зориулж зөвлөхийн боловсруулсан аливаа судалгаа, тайлан, зураг, график, программ хангамж болон бусад материал, эд зүйл нь захиалагчийн өмч болж үлдэх бөгөөд гэрээ дуусгавар болох, гэрээ цуцлахаас өмнө эдгээр материалыг дэлгэрэнгүй жагсаалтын хамтаар захиалагчид хүргүүлнэ. Зөвлөх нь эдгээр бичиг баримт болон программ хангамжийн хувийг авч болно.

3.8 Нягтлан бодох
бүртгэл, Хяналт
шалгалт болон
Аудит

400.54 9019197

Зөвлөх нь гэрээний гүйцэтгэлд хамаарах нягтлан бодох данс, бүртгэлийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмын дагуу хөтлөн явуулах бөгөөд захиалагч түүний томилсон төлөөлөгч эсхүл аудитор эдгээр данс, бүртгэлд хөндлөнгийн шалгалт хийх эрхтэй.

4. ЗӨВЛӨХИЙН АЖИЛТНУУД

4.1 Ажиллах
хүчний
тодорхойлолт

Зөвлөхийн санал болгож буй гол мэргэжилтэн бүрийн албан тушаал, ажлын байрны тодорхойлолт, мэргэжлийн түвшин болон үйлчилгээг гүйцэтгэхэд оролцох хугацаа зэргийн талаарх мэдээллийг Хавсралт №3-т тусгана. Захиалагчтай урьдчилан тохиролцсон гол мэргэжилтний мэдээллийг мөн хавсралтанд багтаана.

4.2 Ажилтныг
халах буюу
солих

(а) Захиалагч зөвшөөрөөгүй бол ажиллах хүчний бүрэлдэхүүнд ямар нэгэн өөрчлөлт хийх ёсгүй. Зөвлөхийн эрх хэмжээнээс үл хамаарах, тухайлбал, тэтгэвэрт гарах, нас барах, эрүүл мэндийн хувьд чадваргүй болох, бусад шалтгааны улмаас ажилтныг солих зайлшгүй шаардлага гарвал түүнтэй тэнцүү буюу илүү чадвартай хүнээр солих асуудлыг цаг алдалгүй тавина.

(б) Аль нэгэн ажилтан үүргээ ноцтой зөрчсөн буюу гэмт хэрэг үйлдсэн, эсхүл үүргийн гүйцэтгэл хангалтгүй байгаа талаар хангалттай үндэслэл захиалагчид байгаа тохиолдолд захиалагчаас бичгээр гаргасан үндэслэл бүхий шаардлагын дагуу түүний хүлээн зөвшөөрхүйц чадвар болон туршлага бүхий ажилтнаар солих ёстой.

(в) Ажилтныг халах, эсхүл солихтой холбоотой үүсч болох ямар нэгэн нэмэлт зардлыг зөвлөх нэхэмжлэх эрхгүй болно.

5. ЗАХИАЛАГЧИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

5.1 Дэмжлэг
үзүүлэх болон
зөвшөөрөл
олгох

Захиалагч нь ГТН-д заасан зөвлөхөд үзүүлэх дэмжлэг, туслалцаа болон холбогдох зөвшөөрлийг засгийн газрын зүгээс олгуулахын тулд бүх талын хүчин чармайлт гаргана.

5.2 Гэрээнд
хэрэглэх
хуулинд татвар
хураамжийн
талаар орсон
өөрчлөлт

Хэрэв, гэрээ байгуулагдсанаас хойш гэрээнд хэрэглэх хуулинд татвар, хураамжийн талаар орсон өөрчлөлтийн улмаас үйлчилгээний гүйцэтгэлийн дагуу Зөвлөхийн хүлээн авах төлбөр нэмэгдэх буюу хасагдахаар байгаа бол, талууд тохиролцон гэрээний дагуу Зөвлөхөд төлөх цалин болон нөхөн төлөгдөх зардлын хэмжээг өөрчлөх бөгөөд энэхүү холбогдох үнийн тохируулга нь ГЕН-ийн 6.2 (а), (б), -д заасан төлбөрийн хэмжээнд нийцсэн байх ёстой.

5.3 Захиалагчийн
зүгээс үзүүлэх
үйлчилгээ,
тоног
төхөөрөмж
болон эд
хөрөнгө

Захиалагч нь үйлчилгээний зорилгоор ашиглуулахаар Хавсралт 3.3-д заасан үйлчилгээ, тоног төхөөрөмж болон эд хөрөнгийг тогтоосон хугацаанд үнэ төлбөргүйгээр Зөвлөхөд гарган өгөх ёстой.

6. ЗӨВЛӨХӨД ТӨЛӨХ ТӨЛБӨР

6.1 Нийт төлбөр

Зөвлөхөд төлөх нийт төлбөрийн хэмжээ нь гэрээний хавсралт №1-т тодорхойлсон үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах бүх зардлыг тооцсон төгтмол нийт үнийг багтаасан гэрээний үнээс хэтрэх ёсгүй. ГЕН-ийн 5.2-т заасны дагуу өөрчлөснөөс бусад тохиолдолд ГЕН-ийн 6.2-т тодорхойлсон үнийн хэмжээг гагцхүү ГЕН-ийн 2.4-т зааснаар талууд нэмэлт төлбөр хийхийг зөвшөөрсөн тохиолдолд нэмэгдүүлж болно.

7. ШУДАРГА БАЙДАЛ

7.1 Шударга байдал

Талууд энэхүү гэрээний дагуу үйл ажиллагаа явуулахдаа бие биенийхээ эрхийг хүндэтгэн, шударга байдлаар хандах ба гэрээний зорилгыг хэрэгжилтийг хангахын тулд бүхий л зохистой арга хэмжээг авна.

8. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

8.1 Маргааныг эв зүйгээр шийдвэрлэх


Маргаанаас зайлсхийх, эсхүл түүнийг цаг алдалгүй шийдвэрлэх нь гэрээний гүйцэтгэлийг сайтар хангах болон төсөл арга хэмжээний амжилтанд ихээхэн чухал гэдгийг талууд хүлээн зөвшөөрнө. Гэрээтэй холбоотой аливаа маргааныг талууд харилцан тохиролцож, эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

8.2 Маргааныг шийдвэрлэх

Талууд гэрээний холбоотой аливаа маргааныг эв зүйгээр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд аль нэг тал нь ГТН-д заасан маргааныг шийдвэрлэх арга хэрэгслийг сонгох эрхтэй.

III. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЭН-ийн зүйлийн дугаар	Гэрээний ерөнхий нөхцлийн холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах буюу өөрчлөнө.
{1.1(а)}	Гэрээнд хэрэглэх хууль нь { Монгол улсын хүчин төгөлдөр хууль болон бусад эрх зүйн актууд}
1.4	<p>Захиалагчийн хаяг: Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3-р баг, Найрамдал хотхон, 3-р байр</p> <p>Захиалагч: Байгаль орчин, аялал жуулчлалын газар</p> <p>Харилцах хүн: Д.Мөнх-Эрдэнэ</p> <p>Утас: 70543063, 99087636</p>
{2.1}	{Гэрээ хүчин төгөлдөр болох өдөр: 2018.04.02}
2.2	Тогтоосон хугацаа: 1 сар буюу 2018 оны 05 сарын 02-ны өдөр хүртэл байна.
2.3	Тогтоосон хугацаа: 1 сар
6.2(б)	Төгрөгөөр хийх төлбөрийн дээд хэмжээ: 9 700 000 есөн сая долоон зуун мянган төгрөг
6.4	<p>Төлбөр хийх данснууд: Төгрөгийн хувьд: Хаан банк, данс: 5135451738</p> <p>Төлбөрийг дараахь хуваарийн дагуу төлнө.</p> <p>(1) Ерөнхий ажлын зураг төсөв бэлэн болж захиалагч байгууллага хянан батласнаар төлөх дүн: Эхний санхүүжилт болох төлбөрийн 50 хувь буюу 4 850 000 дөрвөн сая найман зуун тавин мянган төгрөг</p> <p>(2) Магадлал хийгдсэн иж бүрэн ажлын зураг, хяналтын төсвийг эх 1 хувь, хуулбар 2 хувь, CD файлаар хүлээлгэн өгснийг үндэслэн үлдэгдэл санхүүжилт 4 850 000 дөрвөн сая найман зуун мянган төгрөгийг олгоно.</p>
8.2	Гэрээтэй холбоотой үүссэн маргааныг талууд эв зүйгээр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд шүүх, эсхүл дотоодын болон гадаадын арбитрагийн аль нэгэн байгууллагыг маргааныг шийдвэрлүүлэхээр сонгоно.
8.3	Ажлын баталгааг хангуулах зорилгоор үнийн дүнгийн 1% буюу 97000 төгрөгийг нэг жилийн хугацаанд байршуулна.



ЗӨВЛӨХИЙН АЖЛЫН ДААЛГАВАР

Говьсүмбэр аймгийн Сүмбэр суманд “Услалтын систем хөв цөөрөм байгуулах ажлын зураг төсөв боловсруулах” ажил нь доорх шаардлагыг бүрэн хангасан байх ба, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолтын дагуу хийж гүйцэтгэнэ.

Ажил гүйцэтгэх байршил: Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум

1. Сүмбэр сумын 3-р баг Ногоон хэрэм хөтөлбөрийн хүрээнд таригдсан босоо тэнхлэгийн А-101 автозамын дагуух ойн зурвас,
2. Сүмбэр сумын 3-р баг Найрамдал хотхоны нийтийн эзэмшлийн орон сууцны байрнуудын орцны хажуу талбай,
3. Сүмбэр сумын 4-р баг Цоорхой рашааны тохижилт болон хөв цөөрөм байгуулах ажлын зураг төсөв

АЖЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

Уг ажил нь дараах 4 хэсгээс бүрдэнэ. Үүнд:

1. Ногоон хэрэм хөтөлбөрийн хүрээнд улсын чанартай автозамын дагуух Ойн зурваст услалтын систем, ус нөөцлөх сав суурилуулах ажлын зураг, төсөв.
/зөөврийн усаар цэнэглэх цахилгааны бие даасан холимог эх үүсвэртэй/
2. Найрамдал хотхоны нийтийн эзэмшлийн орон сууцны гадна талбайг зүлэгжүүлэх ажлын услалтын шугам хоолой угсрах ажлын зураг төсөв. /төвлөрсөн усан хангамжаас ашиглах/
3. Цоорхойн булгийн эхийг хамгаалж, тохижуулах, хөв цөөрөм байгуулах ажлын зураг төсөв.
4. Сүмбэр сумын 1, 2 дугаар баг дахь Сүмбэрийн болон Төмөр замын цэцэрлэгийн усалгааны шийдлийн зураг төсөв.

Ерөнхий шаардлага:

Услалтын систем хөв цөөрөм байгуулах ажлын зураг төсвийг боловсруулахдаа хийгдэх ажлын бүлэг, үе шаг бүрт, захиалагч талтай хамтран ажиллаж, хийгдэх ажлын тоо хэмжээг нарийн баримталж, хэмжилт хийж, фото зургаар баталгаажуулан, акт үйлдсэний дараа дараагийн ажил үргэлжлүүлэх зөвшөөрлийг авч ажиллана. Ажил тус бүр дээр ерөнхий ажлын төсөөлөл зураглал гаргаж шийдвэрлэх.

1. Авто замын дагуух Ойн зурваст услалтын систем, ус нөөцлөх сав суурилуулах ажлын зураг, төсөв ажилд тавигдах шаардлага:

Ойн зурвас нь нийт 31 хэсэг хашаа, 11574 ширхэг мод бут таригдсан ба дээрх ажлыг гүйцэтгэхэд эхлээд ажлын ерөнхий зураглал гарган танилцуулах, хашааны урт, өргөн хоорондох зайн хэмжээг нарийвчлан гаргаж, хэсэгчилсэн усалгааны шийдэл гаргаж өгөх шаардлагатай.

Усалгааны системийн бүрдэлд ус нөөцлөх сав, сав суурилуулах өндөрөөс хамаарч хөлний өндөр сонгох, түрэлтийн насос, хаалт, цахилгааны шийдэл /цахилгааны утас, тоолуур, шит/, усалгааны магистрал хоолой, хаалт, холбогчууд, усалгааны шланк зэрэг орно.

Усалгааны 10 тн нөөц савны орчимд цоож бүхий гадна хамгаалалтын төмөр хайрцаг эхсүл дээрх савны суурь хэсгийг ашиглан жижиг байр барьж, хүчин чадалд нь тохирсон түрэлтийн насосыг суурилуулан цахилгаанд холбож, цахилгааны тоолуур суурилуулсан байна. Цэвэр усны нөөцийн савнаас хэрэглэгч тал руу ус шахаж шугамын даралтыг тогтмол хэмжээнд барьж, аюулгүй байдлаа хангаж зөвхөн ус хэрэглэсэн тохиолдолд ажиллаж бусад үед зогсож эрчим хүчний ухаалаг, зохистой хэрэглээг хангахуйц байна.

Усалгааны системийн гол үндсэн шаардлага нь өөрийн даралтаар болон насосны хүчин чадлаар услахад хашааны эцсийн цэгт ирэх усны хэмжээ 1 минутад 30 литр байхаар тооцож усалгааны системийг суурилуулах тооцоололыг хийх.

Хийгдэх ажлын тоо хэмжээ: Засгийн газрын Ногоон хэрэм хөтөлбөрийн хүрээнд таригдсан ойн зурвасын талбай нь аймгийн хэмжээнд улсын чанартай авто замын дагуу байгуулагдсан ба Чойр-Сайншандын чиглэл буюу Бурхантын зоогийн газраас урагш 9 хэсэг хашаа, Чойр-Улаанбаатарын чиглэл буюу Замын цагдаагийн постноос хойш 17 хэсэг хашаа, аймгийн төвд Грийн хаус зоогийн газраас доош замын баруун талдаа 7 хэсэг хашаанууд тус тус багтана.



Замын цагдаагийн Постноос хойшхи замын зүүн талаас эхлэн дугаарласан.

№	Хашааны урт /метр/	Өргөн /метр/	Хашаа хооронд /метр/	Өндөршил		Модны тоо
				Хашааны эхлэл	Хашааны төгсгөл	
1	260	30	10	1291	1291	343
2	391	19	19.5	1285	1276	328
3	298	29.5	18	1272	1269	311
4	1681	29.5	162	1270	1272	1791
5	488	30.5	13	1266	1271	705
6	23 Үдэлт угталтын хаалга	8	-	1270	1270	39
7	65	30	-	1270	1270	40
8	257 автозамын баруун тал	18	7	1272	1269	28
9	328	7	116	1269	1273	432
10	725.5	7	55	1273	1275	1146
11	297	18		1277	1277	182
12	151	18.5	36	1277	1285	282
13	197	29	31	1285	1290	522
14	150	29	37	1290	1290	329
15	181	28	21	1290	1290	389
16	213	29	16	1291	1293	480
Нийт	5105.5	360	-	-	-	7345

Аймгийн төв Грийн хаус зоогийн газрын замын эсрэг талын талбай

№	Хашааны урт /метр/	Өргөн /метр/	Хашаа хооронд /метр/	Өндөршил		Модны тоо
				Хашааны эхлэл	Хашааны төгсгөл	
1	96	4	Авто зам	1292	1286	68
2	112	4	13	1289	1283	71
3	171	4	2	1289	1283	123
4	160	4	19	1286	1283	116
5	175.5	4	42	1281	1283	113
6	57	4	22	1273	1272	34
7	52	4	-	1273	1272	31
Нийт	823.5	-	-	-	-	556

Бурхант зоогийн газраас урагш талбай

№	Хашааны урт /метр/	Өргөн /метр/	Хашаа хооронд /метр/	Өндөршил		Модны тоо
				Хашааны эхлэл	Хашааны төгсгөл	
1	305.5	18	13	1262	1271	340
2	240.5	18	10	1261	1258	343
3	244	18	-	1264	1261	328
4	293	18	14	1258	1254	550
5	340	18	31	1254	1260	371
6	342	17	13	1261	1271	265
7	679	17,5	8.5	1273	1274	1149
8	276	18	13	1274	1281	327
9	220	18	13	1280	1281	-
Нийт	2940	-	-	-	-	3673

1. Найрамдал хотхоны нийтийн эзэмшлийн орон сууцны гадна талбайг зүлэгжүүлэх ажлын услалтын шугам хоолой угсрах ажлын зураг төсөв.

Усалгааны системд тавигдах шаардлага:

Манай аймаг нь говь хээрийн бүсэд хамаардаг тэгш тал гадаргуутай далайн түвшинээс дээш 1000-1200 метр оршино. Гадаргын усны нөөц бага, хур тунадас сүүлийн жилүүдэд багасаж, хуурайшилт нэмэгдсэн.

Иймд зүлэг тарьж ургуулахад усалгаа арчилгаа хамгийн тохиромжтой зөв шийдэлтэй байх шаардлагатай ба зүлэг тарьж ургуулахад үрээр тарьж зөөлөн жигд даралттай бороожуулагч хошуутай усалгааны систем байх шаардлагатай.

Услах талбайн тойрог 2.5-8 метрийн талбайг бүрэн хамарч услах.

Усны эх үүсвэр болох орон сууцныбайрны подволын шугамын усны даралт бага хүрэхгүй байх тохиолдолд насос тавьж болох шийдлийг сонгох.

Усалгааны шугам нь дараах хэсгээс бүрдэнэ: Усалгааны үндсэн болон туслах хоолой, хаалт холбогчууд, бороожуулагч хошуу, цахилгааны болон усны тоолуур байна.

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сум 3-р багт байрлах Найрамдал хотхон нь нийт 12 орон сууцтай. Байр тус бүрийн усалтын систем суурилуулах талбайн хэмжээ.

№	Орон сууцны нэр	Талбайн хэмжээ // м ² /			Тайлбар Байр тус бүрийн орцны тоо
		Урт	Өргөн	Нийт	
1	1-р байр	106	6.5	689	8 орц
2	2-р байр	104	8	832	8 орц
3	3-р байр	93.5	7.5	702	8 орц
4	4-р байр	84.5	7	592	8 орц
5	5-р байр	42	5	210	4 орц
6	6-р байр	52.5	2.5	132	4 орц
7	7-р байр	79.5	4	318	6 орц
8	8-р байр	50.5	6	303	5 орц
9	9-р байр	80	6	480	5 орц
10	10-р байр	65.5	3	197	5 орц
11	11-р байр	65	5	325	5 орц
12	15-р байр	49.5	6	297	5 орц
Нийт	872.5	66.5	5077		

2. Гол горхи, булаг шандны эхийг хамгаалж, тохижуулах, хөв цөөрөм байгуулах ажлын зураг төсөв.

Ерөнхий мэдээлэл: Чойрын Богд уулнаас баруун зүгт 6 орчим км-т байгалийн сонин тогтоцтой, хавцал хадан завсар Хүний дотор эрхтэнд сайн Цоорхойн рашаан байдаг. Тус рашаан нь дээрээс нь тонгойж өндөр дуугаар хашгирахад тэрүүхэндээ элстэй, юутай хээтэйгээ оргилж эхэлдэг. Оргилж гарсан ус нь хэдхэн алд яваад л газартаа шургачихна. Газрын хэвлий цоолдон гарч ирдэг болохоор нь Цоорхойн рашаан гэж нэрлэжээ. Орон нутгийн тусгай хамгаалалтанд 1997 онд авсан.



Рашааны эхийг 2011 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хашиж хамгаалах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Ажил нь дараах хэсгээс бүрдэнэ: Рашаанаас гарч буй усыг хуримтлуулан байгалийн хөв байгуулан хашаажуулах, аялагч амрагч зугаалагч нарт зориулан модон сүүдрэвч, элэгдэл эвдрэл багатай хаягдал түүхий эд материалаар хийгдсэн сандал ширээ, сүүлийн үеийн шинэ шийдэл бүхий байгальд ээлтэй эко ариун цэврийн байгууламжуудаас бүрдэнэ.

Мөн үеийн усны эрсдлийг тооцон хөв болон хашааг төлөвлөнө.

Гүйцэтгэх ажил:

Зураг төсөв боловсруулахдаа дараах ажлуудыг гүйцэтгэнэ. Үүнд:

- 3.1 Зураг төсвийг мэргэжлийн, дадлага туршлагатай боловсон хүчний оролцоотойгоор зөв тооцоолсон байна.
- 3.2. Хөв байгуулах газрын орчимд хээрийн судалгаа хийж хөв байгуулахад ашиглагдах материалыг тодорхойлох.
- 3.3. Хөв байгуулах газрын топографийн зураглал хийх.
- 3.4. Тус газарт усны эх үүсвэрийн ус зүйн тооцоо хийх.
- 3.5. Хөв байгуулах газарт инженер геологийн нөхцөлийг тодорхойлох
- 3.7. Шаардлагатай тохиолдолд толгойн барилгатай байж болох ба усалгааны норм урлах талбайн хэмжээнээс хамааруулан зөв тооцоолсон байх
- 3.8 Үерийн ус дөхүүлэх сувагтай байна.
- 3.9 Усалгааны хэрэглээний нормыг тооцсоны үндсэн дээр хөвийн эзэлхүүнийг тодорхойлох.
- 3.11. Хөвийг үерийн эрсдлээс хамгаалах, үерийн урсацыг байгууламжинд аюулгүй өнгөрөөх инженерийн шийдлийг боловсруулах.
- 3.12. Байгаль орчны доройтол хөрсний эвдрэл, бохирдол үүсгэхгүй байх арга замыг тооцсон байх.
- 3.13. Хөв байгуулах ажилд аль болохоор орон нутгийн материал ашиглах боломжийг судлаж зураг төсөвт тусгах.
- 3.14 Хөв байгуулах газрын гидрогеологи, гидрологийн нөхцөлийг тодорхойлж тусгасан байна.
- 3.15 Цаг уурын олон жилийн судалгаанд суурилж үерийн ус, хур борооны усны уналтыг тооцоолох.


Дөрөв. Тайлан

Зураг төсөл тавигдах шаардлага:

- Зураг төслийн баримт бичиг 3 хувь. Үүнээс: график зураглал CD-ний хамт 2 хувийг захиалагчид, үндсэн хувийг архивт өгнө.
- Хөв болон бусад холбогдох ажлын зургийг UTM координатын системд хийж гүйцэтгэн батлагдсан ажлын зургийг CD-ээр болон цаасан хэлбэрээр бэлдэх.
- Ажлын зурагт бусад инженерийн бэлтгэл арга хэмжээ, шугам сүлжээний одоогийн байдал болон төлөвлөлтийг нэг дэвсгэр зураг дээр нэгтгэн, хоорондын зай хэмжээг огтлолын зургаар тодорхой үзүүлж, норм стандартын дагуу төлөвлөх.
- Бодит байдлын талаарх судалгааг хийх /хээрийн буюу талбайн ажил, геоморфологийн судалгаа гм/
- Захиалагч талын төлөөлөлтэй зөвшилцөж эскиз буюу эх загвар зураг гаргах.
- Усны барилга байгууламжийн угсралтын ажил гүйцэтгэхэд эдийн засгийн хувьд үр ашигтай орчин үеийн дэвшилтэт техник технологи нэвтрүүлэн ашиглахаар тусгах өгөх
- Төлөвлөж буй усан хангамж одоо болон хэтийн төлөвлөлтөөр ачааллыг тусгасан байх
- Усны нөөцийг зүй зохистой, ариг гамтай ашиглах, байгаль орчинд сөрөг нөлөөгүй байхаар хөв цөөрмийг төлөвлөх.
- Дэвсгэр зургийг M1:1000-M1:2000, ажлын зургыг M1:100, M1:500 масштабтайгаар гүйцэтгэх
- Үерийн халиагуурыг үерийн тооцоонд үндэслэн зураглах, төсөвлөх
- Хүн, мал ундаалах, осолдох эрсдэлийг тооцсон байх.

Усалгааны системийн иж бүрэн ажлын зураг, төсөв

- Ойр орчмын төлөвлөлттэй усан хангамж, ариутгах татуургын шугамын төлөвлөлтийг уялдуулж төлөвлөх
- Аймгийн хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн төлөвлөгөөтэй уялдуулах.
- Зураг төсөлийн дагуу гадна шугамын барилга, угсралтын ажилд шаардагдах зардалын хяналтын төсөвийг гаргах.



Ажиллах хүчний график

Д/д	Нэрсийн жагсаалт	Хариуцах чиг үүрэг	Ажлын хуваарь /хуанлийн 5 өдрөөр нийт 30 хоног/					
			1	2	3	4	5	6
1	Н.Шинэболд	Зураг төслийн төлөвлөлт, зохицуулалт	■					
2	Н.Амарбат	Зураглал, гүйцэтгэл		■				
3	Г.Гансүх	Зураглал, гүйцэтгэл	■					
4	А.Өлзийбаатар	Усны барилга, байгууламжийн шийдэл, тооцоо		■				
5	Ш.Энхтөр	Усны барилга, байгууламжийн зураглал			■			
6	А.Ерөөлт	Усалгааны систем, зураглал			■			
7	Р.Цэцэггарав	Төсөв боловсруулах					■	
8	Г.Наранхишиг	Бичиг хэрэг, техникч			■			■
9								



Нутгийн босго ХХК-ны
захирал Г.Цэеэрэгзэн

ТТС 2792 н. 300 1241
УЛААНБААТАР ХОТ

Ажлын график

Д/д	Ажлын жагсаалт	Ажлын хуваарь жуулагийн 5 өдрөөр нийт 30 хоног/					
		1	2	3	4	5	6
1	Гэрээ байгуулах, орон нутагт судалгаа хийх, зураг төслийн ажлуудын хувиарлалт						
2	Зураглалын ажил, гүйцэтгэл, төсөв боловсруулах						
3	Холбогдох байгууллагуудтай зөвшилцөн батлуулах						
4	Магадлал хийлгэх						
5	Гэрээний иж бүрдэлээр хүлээлгэн өгөх, гэрээ дүгнэх						

Нутгийн босго ХХК-ны захирал



Г.Цэеэрэгзэн

Эрвэний 5 дугаар хавиралт



САНХҮҮЖИЛТИЙН ХУВААРЬ

№	Санхүүжилт	Санхүүжилтийн хэмжээ	
		Он, сар, өдөр	Мөнгөн дүн /тоо, үсэг/
1	Урьдчилгаа санхүүжилт	Ерөнхий ажлын зураг төсөв бэлэн болж захиалагч байгууллага хянан батласнаар	4 850 000 <i>дөрвөн сая найман зуун тавин мянган төгрөг</i>
3	Эцсийн санхүүжилт	Магадлал хийгдсэн иж бүрэн ажлын зураг хүлээн авснаар	4 850 000 <i>дөрвөн сая найман зуун тавин мянган төгрөг</i>
Нийт санхүүжилт			9 700 000

